

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан-Уул аймгийн Орхон сумын 8 дугаар сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ДАА-2026/96/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Дархан-Уул аймаг 2026 он	Дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр: Утас: 70378845 Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn Аудитын менежер: У.Батсүрэн Цахим хаяг: batsurenu@audit.gov.mn Ахлах аудитор: С.Батцэцэг Утас: 70373089 Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Хаан консалтинг аудит ХХК Гүйцэтгэх захирал: Э.Нандинчимэг Утас: 88883776 Цахим хаяг: khaanconsultingaudit@gmail.com
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн орон нутгийн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	9
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	9
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	10
3.4 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	11
3.5.1 Төсвийн төлөвлөлт.....	11
3.5.2 Төсвийн гүйцэтгэл	11
3.5.3 Нэмэлт төсөв	12
3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн.....	12
3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл	12
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	12
4.1 Ерөнхий зүйл	12
4.2 Материаллаг байдал.....	13
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	13
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	13
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	13
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	13
4.5.1 Завсрын аудитын талаар.....	13
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	13
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	14
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	14
5.1 Төлбөрийн акт	14
5.2 Албан шаардлага	14
5.3 Зөвлөмж.....	15
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	17

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Бурхантын гудамж-1,14 дүгээр баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45059,
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.25 № 20

танай _____ -ны № _____ -т

ОРХОН СУМЫН 8 ДУГААР СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Г.ИХБАЯР ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Орхон сумын сумын 8 дугаар сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дархан-Уул аймгийн Орхон сумын сумын 8 дугаар сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар Боловсролын газраас бүх цэцэрлэг, сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд зориулан хэрэгцээт багаж хэрэгсэл болон тоног төхөөрөмжийг нийлүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант онд тус байгууллага нь хүүхдийн хоол хүнсний бүтээгдэхүүний зарцуулалтад хяналт сул, холбогдох анхан шатны баримтуудын хөтлөлт дутуу, хүүхдүүдийн ирцийг гүйцэтгэлээр тооцдоггүй, байгууллагын хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан байна.

452050179

Бусад асуудал

Төсвийн шууд захирагч бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Аудитыг гүйцэтгэхдээ Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн хүрээнд авсан судалгаанд дүн шинжилгээ хийж, эрсдэл бүхий асуудалд анхаарал хандуулсан болно.

Дархан-Уул аймгийн Орхон сумын сумын 8 дугаар сургууль нь 2025 онд 10 зорилт 49 арга хэмжээ төлөвлөж, хэрэгжилтийг 92.0 хувиар тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБООС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  МӨНХБАЯР

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	127,071,967.15	84,235,213.44
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	62,929,903.57	26,283,004.86
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	62,929,903.57	26,283,004.86
31211	Төрийн сангийн харилцах	62,929,903.57	26,283,004.86
35	БАРАА МАТЕРИАЛ	64,142,063.58	57,952,208.58
351	Түүхий эд материал	860,700.00	161,600.00
35130	Эм боох материал	860,700.00	161,600.00
354	Хангамжийн материал	63,281,363.58	57,790,608.58
35410	Бичиг хэргийн материал	2,193,300.00	863,200.00
35420	Аж ахуйн материал	6,582,800.00	4,488,700.00
35460	Хүнсний материал	327,500.00	2,272,250.00
35470	Бусад хангамжийн материал	54,177,763.58	50,166,458.58
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,169,918,674.58	1,180,992,209.21
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,169,918,674.58	1,180,992,209.21
392	Биет хөрөнгө	1,127,483,585.64	1,138,613,335.29
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,076,621,060.00	1,076,621,060.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(301,719,217.65)	(310,691,059.83)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	434,120,378.68	452,705,872.48
39206	Хуримтлагдсан элэгдэл	(158,239,358.10)	(164,899,527.10)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	65,733,062.00	51,600,170.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(37,225,279.25)	(17,830,280.42)
39214	Бусад үндсэн хөрөнгө	15,289,860.00	7,185,380.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(9,446,922.72)	(5,194,282.92)
39217	Ном	42,350,002.68	49,116,003.08
393	Биет бус хөрөнгө	42,435,088.94	42,378,873.92
39301	Програм хангамж	1,124,300.00	1,124,300.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(665,211.06)	(721,426.08)
39303	Бусад биет бус хөрөнгө	41,976,000.00	41,976,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,296,990,641.73	1,265,227,422.65
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	64,285,003.15	49,323,448.21
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	64,285,003.15	49,323,448.21
413	Өглөг	64,285,003.15	49,323,448.21
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	3,598,103.15	7,291,448.21
4136	Бусад өглөг	60,686,900.00	42,032,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	60,686,900.00	39,522,000.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг		2,510,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,232,705,638.58	1,215,903,974.44
51	Засгийн газрын хувь оролцоо	1,232,705,638.58	1,215,903,974.44
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	270,560,830.28	270,560,830.28
51101	Өмч: - төрийн	270,560,830.28	270,560,830.28
512	Хуримтлагдсан үр дүн	(22,697,526.58)	(39,499,190.72)
51210	Өмнөх үеийн үр дүн	(22,697,526.58)	(22,697,526.58)
51220	Тайлант үеийн үр дүн	-	(16,801,664.14)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	984,842,334.88	984,842,334.88
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,296,990,641.73	1,265,227,422.65

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,843,428,954.66	2,395,133,415.80
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	32,741,654.66	64,205,515.80
120	Нийтлэг татварын бус орлого	32,741,654.66	64,205,515.80
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	492,800.00	5,671,488.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	492,800.00	3,071,488.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	2,600,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	16,548,554.66	51,045,900.40
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	15,700,300.00	7,488,127.40
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,810,687,300.00	2,330,927,900.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,606,459,700.00	2,070,289,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,606,459,700.00	2,070,289,200.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	204,227,600.00	260,638,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	204,227,600.00	260,638,700.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,934,597,493.28	2,407,942,233.35
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,934,597,493.28	2,407,942,233.35
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,869,277,481.07	2,313,384,527.60
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,331,956,387.04	1,703,987,539.63
210101	Үндсэн цалин	859,882,954.29	968,848,440.78
210102	Нэмэгдэл	435,542,679.63	655,978,905.55
210103	Унаа хоолны хөнгөлөлт		23,813,273.14
210104	Урамшуулал	36,530,753.12	55,346,920.16
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	164,664,319.89	212,155,868.78
210201	Тэтгэврийн даатгал	112,165,345.92	144,265,818.77
210202	Тэтгэмжийн даатгал	13,195,869.08	16,972,537.51
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,624,962.70	8,486,318.75
210204	Ажилгүйдлийн даатгал	6,535,808.45	8,486,318.75
210205	Эрүүл мэндийн даатгал	26,142,333.74	33,944,875.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	179,433,205.79	224,757,123.45
210301	Гэрэл, цахилгаан	11,203,950.54	16,240,542.82
210302	Түлш, халаалт	159,729,615.25	200,904,020.63
210303	Цэвэр, бохир ус	8,499,640.00	7,612,560.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	1,535,612.40
210404	Ном, хэвлэл		1,535,612.40
2105	Нормативт зардал	25,109,152.00	33,108,590.00
210502	Хоол, хүнс	25,109,152.00	33,108,590.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,000,000.00	12,528,800.00
210604	Урсгал засвар	8,000,000.00	12,528,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	18,995,625.65	20,129,534.16
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	614,600.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	18,381,025.65	20,129,534.16
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	141,118,790.70	105,181,459.18
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	36,367,226.70	48,126,340.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	11,787,452.00	9,906,300.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	92,964,112.00	47,148,819.18
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	65,320,012.21	94,557,705.75
2132	Бусад урсгал шилжүүлэг	48,525,618.00	68,206,041.20
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж		
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж		
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	48,525,618.00	47,462,961.20

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		20,743,080.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	16,794,394.21	26,351,664.55
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	16,794,394.21	26,351,664.55
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(91,168,538.62)	(12,808,817.55)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	3,992,846.59
225010	Үнэ төлбөргүй гарсан зардал - Үндсэн хөрөнгө		3,992,846.59
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(3,992,846.59)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(91,168,538.62)	(16,801,664.14)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,811,180,100.00	2,336,599,388.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	492,800.00	5,671,488.00
120	Нийтлэг татварын бус орлого	492,800.00	5,671,488.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	492,800.00	5,671,488.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	492,800.00	3,071,488.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		2,600,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,810,687,300.00	2,330,927,900.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,606,459,700.00	2,070,289,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,606,459,700.00	2,070,289,200.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	204,227,600.00	260,638,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	204,227,600.00	260,638,700.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,832,062,578.13	2,351,571,286.71
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,832,062,578.13	2,351,571,286.71
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,771,968,973.92	2,255,684,630.96
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,328,358,283.89	1,700,294,194.57
210101	Үндсэн цалин	856,284,851.14	965,155,095.72
210102	Нэмэгдэл	435,542,679.63	655,978,905.55
210103	Унаа хоолны хөнгөлөлт		23,813,273.14
210104	Урамшуулал	36,530,753.12	55,346,920.16
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	164,664,319.89	212,155,868.78
210201	Тэтгэврийн даатгал	112,165,345.92	144,265,818.77
210202	Тэтгэмжийн даатгал	13,195,869.08	16,972,537.51
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,624,962.70	8,486,318.75
210204	Ажилгүйдлийн даатгал	6,535,808.45	8,486,318.75
210205	Эрүүл мэндийн даатгал	26,142,333.74	33,944,875.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	179,433,205.79	224,757,123.45
210301	Гэрэл, цахилгаан	11,203,950.54	16,240,542.82
210302	Түлш, халаалт	159,729,615.25	200,904,020.63
210303	Цэвэр, бохир ус	8,499,640.00	7,612,560.00
2105	Нормативт зардал	27,086,860.00	33,724,390.00
210502	Хоол, хүнс	27,086,860.00	33,724,390.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,000,000.00	12,601,400.00
210604	Урсгал засвар	8,000,000.00	12,601,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	18,995,625.65	20,129,534.16
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	614,600.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	18,381,025.65	20,129,534.16
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	45,430,678.70	52,022,120.00

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	33,643,226.70	45,135,920.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	11,787,452.00	6,886,200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	60,093,604.21	95,886,655.75
2132	Бусад урсгал шилжүүлэг	43,299,210.00	69,534,991.20
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	43,299,210.00	48,791,911.20
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	20,743,080.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	16,794,394.21	26,351,664.55
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	16,794,394.21	26,351,664.55
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	(20,882,478.13)	(14,971,898.71)
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	19,013,100.00	21,675,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	19,013,100.00	21,675,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	19,013,100.00	21,675,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	19,013,100.00	21,675,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(19,013,100.00)	(21,675,000.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(39,895,578.13)	(36,646,898.71)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	102,825,481.17	62,929,903.57
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	62,929,903.57	26,283,004.86

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/Төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	270,560,830.28	984,842,334.88	68,471,012.04	1,323,874,177.20
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	270,560,830.28	984,842,334.88	68,471,012.04	1,323,874,177.20
Тайлант үеийн үр дүн	-	-	(91,168,538.62)	(91,168,538.62)
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	270,560,830.28	984,842,334.88	(22,697,526.58)	1,232,705,638.58
2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	270,560,830.28	984,842,334.88	(22,697,526.58)	1,232,705,638.58
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	270,560,830.28	984,842,334.88	(22,697,526.58)	1,232,705,638.58
Тайлант үеийн үр дүн	-	-	(16,801,664.14)	(16,801,664.14)
2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	270,560,830.28	984,842,334.88	(39,499,190.72)	1,215,903,974.44

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
11000	Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл	-	62,929,903.57	(62,929,903.57)
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,150,227,600.00	2,109,536,098.71	40,691,501.29
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,150,227,600.00	2,109,536,098.71	40,691,501.29
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,150,227,600.00	2,109,536,098.71	40,691,501.29
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,707,034,500.00	1,700,294,194.57	6,740,305.43
210101	Үндсэн цалин	1,025,777,700.00	965,155,095.72	60,622,604.28
210102	Нэмэгдэл	631,926,200.00	655,978,905.55	(24,052,705.55)
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	23,813,273.14	(23,813,273.14)
210104	Урамшуулал	49,330,600.00	55,346,920.16	(6,016,320.16)
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	215,016,400.00	212,155,868.78	2,860,531.22
210201	Тэтгэврийн даатгал	145,775,200.00	145,517,434.68	257,765.32
210202	Тэтгэмжийн даатгал	17,310,400.00	17,021,816.99	288,583.01
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,655,100.00	8,486,318.75	168,781.25
210204	Ажилгүйдлийн даатгал	8,655,100.00	8,349,989.56	305,110.44
210205	Эрүүл мэндийн даатгал	34,620,600.00	32,780,308.80	1,840,291.20
2105	Нормативд зардал	35,452,400.00	33,724,390.00	1,728,010.00
210502	Хоол хүнс	35,452,400.00	33,724,390.00	1,728,010.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	24,504,200.00	20,129,534.16	4,374,665.84
210806	Мэдээллийн технологийн үйлчилгээ	24,504,200.00	20,129,534.16	4,374,665.84
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	76,793,800.00	73,697,120.00	3,096,680.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	67,998,800.00	66,810,920.00	1,187,880.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,795,000.00	6,886,200.00	1,908,800.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	91,426,300.00	69,534,991.20	21,891,308.80
2132	Бусад урсгал шилжүүлэг	91,426,300.00	69,534,991.20	21,891,308.80
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	70,683,200.00	48,791,911.20	21,891,288.80
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	20,743,100.00	20,743,080.00	20.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,150,227,600.00	2,072,889,200.00	(516,028,000.00)
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,150,227,600.00	2,070,289,200.00	79,938,400.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	2,085,013,100.00	2,070,289,200.00	14,723,900.00
	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	65,214,500.00	2,600,000.00	62,614,500.00
	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,600,000.00	2,600,000.00	-
	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	62,614,500.00		62,614,500.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	62,929,903.57	(62,929,903.57)
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	26,283,004.86	(26,283,004.86)

2.6 Аудит хийсэн орон нутгийн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	260,638,700.00	237,358,523.45	23,280,176.55
21	УРСГАЛ ЗАРДАЛ	260,638,700.00	237,358,523.45	23,280,176.55
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	260,638,700.00	237,358,523.45	23,280,176.55
2103	БАЙР АШИГЛАЛТТАЙ ХОЛБООТОЙ ТОГТМОЛ ЗАРДАЛ	247,978,700.00	224,757,123.45	23,221,576.55
210301	Гэрэл, цахилгаан	16,068,500.00	16,240,542.82	(172,042.82)
21302	Түлш халаалт	221,383,800.00	200,904,020.63	20,479,779.37
21303	Цэвэр, бохир ус	10,526,400.00	7,612,560.00	2,913,840.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,660,000.00	12,601,400.00	58,600.00
210604	Урсгал засварын зардал	12,660,000.00	12,601,400.00	58,600.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	260,638,700.00	237,358,523.45	-
122	Тусламжийн орлого	260,638,700.00	237,358,523.45	-
122005	Төсвөөс санхүүжих	260,638,700.00	237,358,523.45	-

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Дархан-Уул аймгийн Орхон сумын 8 дугаар сургуулийн нь эрхэм зорилго нь Суралцах суурь чадвараа хөгжүүлсэн зөв харилцаатай эрүүл чийрэг хүүхэд төлөвшүүлнэ. Алсын хараа: Суралцах чадвартай, суурь мэдлэгтэй хичээл зүтгэлтэй иргэнийг бий болгоход оршино.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус газар нь Төсвийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Татварын ерөнхий хууль, Нийгмийн даатгалын ерөнхий хууль болон холбогдох дүрэм, журмыг үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Тайлант хугацаанд Төрийн албаны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль зэрэг үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна.

Төсвийн шууд захирагч зарлагын гүйлгээнд гарын үсэг зурснаар дотоод хяналтыг хэрэгжүүлж байгаа бол аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс холбогдох санхүүгийн баримт материал, гэрээ, гүйцэтгэлийн баримт бичгийг хянаж, зарлагын гүйлгээг хийж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг үр нөлөөтэй гэж тодорхойлон, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэх шаардлагагүй гэж үзсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дархан-Уул аймгийн Орхон сумын 8 дугаар сургууль нь 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллага нь 2020 онд хэвлэгдэн гарсан мэргэшсэн нягтлан Ш.Отгоны боловсруулсан "Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг үйл ажиллагаандаа мөрдөж байгаа бөгөөд нягтлан бодох бүртгэлийн стандарт, санхүүгийн программтай нийцэх оновчтой агуулгагүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Дархан-Уул аймгийн Орхон сумын 8 дугаар сургууль нь 2025 оны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д заасан бүрэлдэхүүнээр, Сангийн сайдын 2025 оны А/З дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 31,763.2 мянган төгрөгөөр буюу 3.0 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	62,929.9	26,283.0	(36,646.9)
Авлага	-	-	-
Бараа материал	64,142.1	57,952.2	(6,189.9)
Үндсэн хөрөнгө	1,169,918.6	1,180,992.2	11,073.6
Нийт хөрөнгө	1,296,990.6	1,265,227.4	(31,763.2)
Өр төлбөр	64,285.0	49,373.4	(14,911.5)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,232,705.6	1,215,853.9	(16,851.7)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,296,990.6	1,265,227.4	(31,763.2)

Дээрх хүснэгтээс харахад дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлт гарчээ. Үүнд:

Тайлант хугацаанд мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 26,283.0 мянган төгрөг болж 36,646.9 мянган төгрөгөөр буурсан нь төсөвлөсөн зардлаас тухайн жилийн төсөвт нэмж тодотгон зарцуулснаас шалтгаалжээ.

Бараа материал дансны үлдэгдэл нь 57,952.2 мянган төгрөг болж 6,189.9 мянган төгрөгөөр буурсан нь эргэлтийн хөрөнгийн тооллогыг сүүлийн 2 жилд хийгээгүй байсан ба тооллогыг зохион байгуулж, ашиглалтын хугацаа дуусан хэрэглээнд гарсан бараа материалыг нэгтгэн захирлын тушаалаар актласантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,180,992.2 мянган төгрөг болж өмнөх оноос 11,073.6 мянган төгрөгөөр өссөн нь Гүйцэтгэлийн үнэлгээгээр үнэлэгдсэний урамшуулал 11,073.6 мянган төгрөгөөр машин тоног төхөөрөмж худалдан авсантай холбоотой.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 1,265,227.4 мянган төгрөг болж өмнөх оноос 31,763.2 мянган төгрөгөөр буурсан нь тайлант хугацаанд 3 жилийн хугацаатай лизингийн үйлчилгээгээр авсан цахим ангийн зээлийн төлөлтийг хуваарийн дагуу барагдуулсан. Мөн тайлант онд цалингийн сангийн төсөв дутуу, өмнөх оны үлдэгдэлээс тодотголоор төсөв олгосонтой холбоотой.

3.4 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд нийт зарлага ба зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,894,400.0 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 260,600.0 мянган төгрөг, урьд оны үлдэгдлээс 62.6 мянган төгрөг, нийт зарлагыг 1414.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснийг улсын төсвийн санхүүжилтийг 803 мянган төгрөгөөр өсгөж 1,091.4 мянган төгрөг, орон нутгийн төсвийг саналын дагуу 260.6 мянган төгрөг, нийт 1,352.0 мянган төгрөгөөр баталсан байна.

Тайлант онд төсвийн хуваарьт 4 удаа өөрчлөлт орж, улсын төсвийг 169.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон бол орон нутгийн төсөвт тодотгол хийгээгүй байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 15 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 2,070,400.0 мянган төгрөг, урьд оны үлдэгдлээс 62,929.9 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 260,600.0 мянган төгрөг, нийт 2,393,600.0 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 2,072,800.0 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 260,600.0 мянган төгрөг, нийт 2,333,400.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, зарлагын гүйцэтгэл 2348.4 мянган төгрөг буюу 100.6 хувьтай зарцуулж, орон нутгийн төсвөөс зарцуулаагүй үлдсэн 26,351.6 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлснээр мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 36,646.8 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
71802	Ерөнхий боловсрол	2,355,720.6	2,313,920.6	(41,800.00)	98.2
80111	Нийтлэг үйлчилгээ	204,227.6	204,227.6	-	100.0
80226	Байр ашиглалтын үйлчилгээ	2,576.1	2,432.5	(143.60)	94.4
80233	Хүүхэд хамгаалал	2,502.1	2,502.1	-	100.0
80312	Сургалт семинарын зардал	1,941.4	1,920.0	(21.40)	98.9
81605	Эрүүл мэндийг дэмжих	2,663.0	2,663.0	-	100.0
81801	Үдийн хоолны зардал	70,683.2	48,791.9	(21,891.30)	69.0
81806	Дотуур байр	255,288.7	245,779.6	(9,509.10)	96.3
81816	Зөв Монгол хүүхэд үндэсний хөтөлбөр	21,675.0	21,675.0	-	100.0
81823	Боловсролын байгууллагын ажилтны мэргэжил дээшлүүлэх	6,323.1	5,670.2	(652.90)	89.7
81834	Боловсролын стандарт, сургалтын үйл ажиллагаа	1,697,709.7	1,689,651.9	(8,057.80)	99.5
81835	Сургалтын хэвийн үйл ажиллагаа	79,326.2	79,310.1	(16.10)	100.0

83602	ЗГ болон ЗД-ын нөөц хөрөнгөөс хуваарилсан	500.0	500.0	-	100.0
81875	Сургуулийн нэмэлт хөтөлбөр хэрэгжүүлэх	8,204.5	6,796.7	(1,407.80)	82.8
83603	Нэмэлт - Дээд шатны төсвөөс хуваарилсан	2,100.0	2,000.0	(100.00)	95.2

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Боловсролын сайдын 2024.10.14-ний өдрийг 1/1536, 2025.02.11-ний өдрийн 1/554 Чиглэл хүргүүлэх албан тоот бичгийн дагуу унааны хөнгөлөлтийг 0.5 мянган төгрөгөөр, хоолны хөнгөлөлтийг 5.0 мянган төгрөгөөр баталж, 23,813.2 мянган төгрөг зарцуулсан байна.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд харьцуулалтын аргаар харуул хамгаалалтын үйлчилгээний 33,724.5 мянган төгрөгийн худалдан авах ажиллагааг зохион байгуулж, бүрэн хэрэгжүүлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн худалдан авах ажиллагаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Дархан-Уул аймгийн Орхон сумын 8 дугаар сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд Дархан-Уул аймгийн Орхон сумын 8 дугаар сургууль, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн бараа үйлчилгээний зардлын анхан шатны баримтын бүрдэлттэй холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Хаан консалтинг аудит ХХК-ийн аудитор Ч.Баярсайхан, аудиторын туслах Э.Тунгалагтамир нар гүйцэтгэж, чанарын хяналтыг Хаан консалтинг аудит ХХК-ийн чанарын хяналтын менежер Г.Ганцэцэг, Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор С.Батцэцэг, аудитын менежер У.Батсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Дархан-Уул аймгийн Орхон сумын 8 дугаар сургууль нь 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дархан-Уул аймгийн Төрийн аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 03 тоот албан бичигтэй боловч санхүүгийн тайланг биетээр 2026 оны 01 дүгээр сарын 27-ны өдөр ирүүлсэн.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2025 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэлсэн.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2025 оны батлагдсан төсөв 2,114,390.0 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 31,715.8 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тайлант онд улсын төсвөөс зарцуулаагүй үлдэгдэл 9.6 мянган төгрөг төвлөрүүлсэн нь Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулиар тэвчиж болох зардлыг хэмнэх ажлын хүрээнд төсвийн байгууллагуудын санхүүжилт, зарцуулалтын эрхийг хязгаарлаж, гүйцэтгэлээр санхүүжүүлсэнтэй холбоотой байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тус сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд завсрын аудит хийж, нийт 18,483.5 мянган төгрөгийн алдаа зөрчил илрүүлж, жилийн эцсийн аудитаар горим сорил хэрэгжүүлэхэд зөрчлийг арилгасан байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар хавсран ажилласан ажилтанд нэмэгдэл олгосон зөрчилд 347.2 мянган төгрөгийн төлбөрийн акт, өр төлбөрийн тооцоо үүсгэсэн, тушаал шийдвэргүй нэмэгдэл хөлс олгосон 19,529.9 мянган төгрөгийн 2 зөвлөмжийн хэрэгжилтийг 2025 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар тулган шалгахад 100 хувь хэрэгжүүлж ажилласан байна.

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	347.2	1	347.2	100.0
Зөвлөмж	2	19,529.9	2	19,529.9	100.0
Нийт дүн	3	19,877.1	3	19,877.1	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 84,294.5 мянган төгрөгийн зөрчил¹ илэрсэн тул 2 төлбөрийн акт, 1 албан шаардлага, 2 зөвлөмж хүргүүлээ. Үүнд:

5.1 Төлбөрийн акт

1. Тайлант онд тус сургуулийн хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардлаас хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтад хамрагдсан захирал Г.Ихбаярын сургалтын төлбөрт 600,000.00 төгрөг төлж, батлагдсан төсвийг үр ашиггүй зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 39 дүгээр тогтоолоор баталсан "Хувьсах зардал болон гүйцэтгэл, үр дүнд суурилан санхүүжүүлэх журам"-ын хавсралт "Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн нэг суралцагчид ногдох хувьсах зардлын хэмжээний бүрэлдэхүүн, зардлын зориулалт, эдийн засгийн ангиллын дэлгэрэнгүй заавар"-ын 7-д "Хичээл, практикийн зардалд лаборатори, кабинетын сургалтын хэрэглэгдэхүүний жагсаалтад байхгүй материал, бичгийн цаас, шохой, бал, маркер, принтерийн хор, судлагдахууны онцлогтой хэрэглэгдэх, туршилт дадлагын явцад шаардагдах химийн урвалж бодис, технологийн хичээлийн бэлдэц, мод материал, сагсан бөмбөг, хөл бөмбөг, тугалган цаас, лаа, зай, хадаас, оёдлын утас, даавуу гэх мэт хөрөнгийн бус хангамжийн материал багтана" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.
2. Тайлант онд тэмцээн уралдаан зохион байгуулж цом, өргөмжлөл худалдан авахад 1,000,000.00 төгрөгийг зарцуулж, батлагдсан төсвийг үр ашиггүй зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно", 15.1.8-д Байгууллагын төсвөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

5.2 Албан шаардлага

1. Тайлант онд тус сургуулийн захирал Г.Ихбаяр нь Дархан-Уул аймгийн Боловсролын газрын даргын 2025 оны А/94 дүгээр тушаалыг үндэслэн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцан ажилласны нэмэгдэл цалин хөлсөнд нийт 2,122,973.91 төгрөг авч, хууль тогтоомжийн хүрээнд хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлээгүй нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д "Төсвийн

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1-д "Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах, хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, хяналт тавих үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын захирал /эзэн/, ажил олгогч шууд хариуцна", 27.6-д "Аж ахуйн нэгж, байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан бүтцийн жишиг, ажилтны орон тооны норматив, зөвлөлийн ажиллах үлгэрчилсэн журмыг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална", Хөдөлмөрийн сайдын 2015 оны А/114 дүгээр тушаалын 1.В хэсэгт "Төрийн болон төрийн үйлчилгээний төсвийн байгууллага ажилтны тооноос хамаарахгүйгээр Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлыг аль нэг ажилтанд хавсран хариуцуулна. Хавсран ажиллуулсан тохиолдолд Хөдөлмөрийн тухай хуулийн 50 дугаар зүйлд заасны дагуу үндсэн ажлын цалингийн 40 хүртэлх хувийн нэмэгдэл хөлс олгоно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

5.3.1 Санхүүгийн тайлан хүргүүлэхтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Санхүүгийн тайланг хуулийн тогтоосон хугацаанд аудитын байгууллагад ирүүлээгүй нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д "Төсвийн шууд захирагч улирлын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа улирлын эхний сарын 15-ны дотор гаргаж харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн санхүүгийн тайланг 02 дугаар сарын 25-ны дотор харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1 дэх заалтыг баримталж, тогтоосон хугацаанд санхүүгийн тайланг Төрийн аудитын байгууллагад хүргүүлж байх

5.3.2 Дотоод хяналттай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Үдийн хоолны зарцуулалтыг тулгахад хүнсний ул мөрийн дэвтэр хөтлөлт хангалтгүй дутуу тэмдэглэгдсэн, хүүхдийн ирцийг бодит гүйцэтгэлээр биш дундаж тоогоор /200 хүүхэд/ тооцоолон өдөр бүр хоол үйлдвэрлэл хийдэг, хүнсний материал зарцуулалт үнэн зөв эсэхэд эргэлзээтэй, биет горим хэрэгжүүлэхэд бодит тоон үлдэгдэл зөрүүтэй нийт 80,571.5 мянган төгрөгийн хүнсний материал зарцуулагдсан байгаа нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д "Төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", 16.5.2-т "Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4-т "Нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1 дэх, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4 дэх заалтыг баримталж, хүүхдийн хоолны материалын зарцуулалтад хяналт тавих

Дээрх тайлангийн 5.1 дэх хэсэгт дурдсан төлбөрийн акт, 5.2 дахь хэсэгт дурдсан албан шаардлага, 5.3 дахь хэсэгт дурдсан зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5²-д заасны дагуу ирүүлэх, биелэлтийг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

² Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс								Тайл бар
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	
Тайлант онд тус цэцэрлэгийн бараа, үйлчилгээний бусад зардлаас хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтад хамрагдсан сургалтын төлбөр төлж, батлагдсан төсвийг үр ашиггүй зарцуулсан.	1	600.0	1	600.0	-	-	-	-	-	-	
Тайлант онд тэмцээн уралдаан зохион байгуулж цом, өргөмжлөл худалдан авахад 1,000,000.00 төгрөгийг зарцуулж, батлагдсан төсвийг үр ашиггүй зарцуулсан	1	1,000.0	1	1,000.0							
Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцан ажилласны нэмэгдэл цалин хөлс авч, хууль тогтоомжийн хүрээнд хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлээгүй	1	2,122.9	-	-	1	2,122.9	-	-	-	-	
Санхүүгийн тайланг хуулийн тогтоосон хугацаанд аудитын байгууллагад ирүүлээгүй	1	-	-	-			1	-	-	-	
Дүн	4	3,722.9	2	1,600.0	1	2,122.9					

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Үдийн хоолны зарцуулалтыг тулгахад хүнсний үл мөрийн дэвтэр хөтлөлт хангалтгүй дутуу тэмдэглэгдсэн, хүүхдийн ирцийг бодит гүйцэтгэлээр биш дундаж тоогоор /200 хүүхэд/ тооцоолон өдөр бүр хоол үйлдвэрлэл хийдэг, хүнсний материал зарцуулалт үнэн зөв эсэхэд эргэлзээтэй, биет горим хэрэгжүүлэхэд бодит тоон үлдэгдэл зөрүүтэй	1	80,571.5			1	80,571.5		
Дүн	1	80,571.5	-	-	1	80,571.5		